



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 0153

Чингис хот

Комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 2 дугаар хуралдааны 04 тоот тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Хэрлэн Цогт-Өндөр багийн 6 дугаар цэцэрлэгийн засвар” ХЭАХЭСЗДТГ/20250601017 дугаар бүхий ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: А.Боргил-Хэрлэн сумын Засаг даргын Орлогч
Нарийн бичиг: Д.Мөнхтуяа- Цогт-Өндөр багийн Засаг дарга
Гишүүд: Э.Золбаяр- Барилга, дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
Т.Хосбаяр- Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын нярав
Зөвшилцсөнөөр: Г.Санчир- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хяналтын инженер

2.“Хэрлэн Цогт-Өндөр багийн 6 дугаар цэцэрлэгийн засвар” ХЭАХЭСЗДТГ/20250601017 дугаар бүхий ажлыг гэрээнд заасны дагуу хүлээн авч үр дүнг танилцуулахыг комиссын дарга (А.Боргил)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР